

Сүхбаатар аймгийн Ус Цаг Уур Орчны шинжилгээний төвийн
2024 оны 3 дугаар улирлын ажлын тайлан

Нэг. Ерөнхий тойм

Сүхбаатар аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь үйл ажиллагаандаа “Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай” хууль, “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хууль, “Төсвийн тухай” хууль, “Монгол Алсын хараа–2050 хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдлөг болгон МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур орчны шинжилгээний газраас батлан гаргасан ус цаг уур орчны шинжилгээний хөтөлбөрт ажлын тасралтгүй байдал, технологийн мөрдөлтийг хангах, салбар нэгжийг мэргэжлийн арга зүйгээр удирдах, ажилчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, ус цаг уур орчны мэдээ мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэхэд ажлаа чиглүүлэн ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт хагас жилийн байдлаар 92.1%-тай хэрэгжсэн байна. Аймгийн засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний биелэлт одоогоор дүгнэгдээгүй байна.

Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын болон төр захиргааны дээд байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэн Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжүүдийг арга зүй, технологийн удирдлагаар хангаж, тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх стратегийн зорилтын хүрээнд зохион байгуулсан ажил үйлчилгээ:

1.1 Дээд газрын тушаал, шийдвэрийн биелэлт

Байгаль орчин, аялал жуулчлааын сайдын 2018 оны А/81 тоот тушаал, ЦУОШГазрын даргын 2023 оны 05 сарын 16-ны өдрийн А/83 тоот тушаалаар батлагдсан УЦУОШТөвийн орон тооны дээд хязгаар 58 хүний орон тоотой бөгөөд Захиргаа санхүү мэдээлэл үйлчилгээний хэлтэс, цаг уур орчны шинжилгээний хэлтэс гэсэн 2 хэлтэс, 4 өртөө, ХАА-н цаг уурын шинжилгээний 9 харуул, ус судлалын 1 харуул, цаг агаарт зориудаар нөлөөлөх 3 экспедици, Байгаль орчны шинжилгээний лаборатори, Баруун-Урт сумын агаарын чанарын хяналтын харуул гэсэн нэгжтэй үйл ажиллагаагаа хөтөлбөрийн дагуу явуулж байна.

Төрийн албан тухай хууль, Төсвийн тухай хуулийн хүрээнд ЦУОШГазрын дарга, аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг байгуулж биелэлтийг хангаж ажилласан.

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн хүрээнд 2024 оны багаж хэмжлийн график төлөвлөгөөг 01-р сарын 18-ны өдөр БОХЗТЛабораторийн дарга, УЦУОШТөвийн даргатай хамтран баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Шалгалт тохирууллагын эталон тоон заалттай барометр1950009 серийн дугаартай, гэрчилгээний дугаар Г-2024/15, чийгшлийн мэдрүүр , температурын мэдрүүр серийн дугаар К0750007, гэрчилгээний дугаар АӨ-2024/911 этолон багажууд график төлөвлөгөөний дагуу БОХЗТЛабораторид хугацаандаа баталгаажсан байна.

2024 онд шинжилгээний ажилд ашиглагдаж байгаа 16 нэр төрлийн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулага, үзлэг үйлчилгээ хийх төлөвлөгөө батлагдсан, 3 өртөө /Баруун урт, Дарьганга, Эрдэнэцагаан/, 9-н ХАА-н цаг уурын харуулийн /Асгат, Түмэнцогт, Сүхбаатар,Түвшинширээ, Халзан, Онгон, Наран, Мөнххаан, Сүхбаатар,/ нийт давхардсан тоогоор 39 цаг уурын багаж хэмжих хэрэгсэлд үзлэг үйлчилгээ, тохируулага хийсэн байна.

2024 онд баталсан график төлөвлөгөөний дагуу 16 төрлийн давхардсан тоогоор 81 ширхэг цаг уурын хэмжих хэрэгслийн багажинд үзлэг үйлчилгээ хийхээс 3 дугаар улирлын байдлаар 59 ширхэг шинжилгээний багажинд үзлэг үйлчилгээ, тохируулага хийж хэрэгжилт 70,1 хувьтай байна.

2024 оны 3 дугаар улиралд цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх болон анхааруулах мэдээ, урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ, 1 хоногийн тойм мэдээ, 7 хоногийн тойм мэдээ, сар болон улирлын тойм мэдээнүүдийг гаргаж олон нийтэд хүргэсэн ба сэрэмжлүүлэг мэдээний таарц 85,9%, онч нь 100%, илрүүлэлт 100%-тай байна. Нийт анхааруулах болон сэрэмжлүүлэх мэдээг 30 удаа, урьдчилан сэрэмжлүүлэх мэдээг 1 удаа, 1 хоног болон 5 хоногийн мэдээг 92 удаа, 7 хоногийн мэдээг 14 удаа, сар болон улирлын мэдээг 6 удаа тус бүр гаргаж ОБГ, гэрээт газрууд, ард иргэд аж ахуйн нэгжүүдэд орон нутгийн TV, мэдээллийн самбар, байгууллагын сошиал/фейсбүүк/ хаягаар түргэн шуурхай ил тод мэдээлж ажилласан.

2024 онд БОАЖ-ын сайдын хөрөнгө оруулалтын багцаас УЦУОШТөвийн барилгын дотор их засвар, УЦУ-н шинжилгээний Эрдэнэцагаан өртөөний барилгын дотор их засварын санхүүжилт шийдвэрлэсэн ба Тендерийг 6-р сард зарлаж одоогоор төвийн барилгын дотор их засварын ажлыг ХХК хийж гүйцэтгэхээр болж засварын ажил эхлээд явж байна.

Монгол Улсын Засгийн газрын 96 дугаар тогтоолоор батлагдсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх” үйл ажиллагааны хүрээнд 6, 7, 8-р сард байгууллагын 3 экспедици 9 хүний бүрэлдэхүүнтэй нийт 10 удаагийн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулж 21 пуужин харваж бүх сумдын нутгаар хур тунадас нэмэгдүүлэн ажилласан байна. Дээд газраас энэ онд 50 ширхэг пуужин хангалтаар өгсөн бөгөөд одоогоор 29 ш пуужингийн үлдэгдэлтэй байна.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үеийн зураг.



Байгаль орчны шинжилгээний лабораторид хийгдэж буй ажил үйлчилгээ:

Агаар дахь бохирдуулагч элемент болох азотын давхар ислийн 62 өдрийн 124 дээжид шинжилгээг хийж гүйцэтгэхэд хамгийн өндөр агууламж 17мкг/м3, улирлын дундаж агууламж 13мкг/м3 хэмжээтэй байна. Хүхрийн давхар ислийн 62 удаагийн 124 дээжид шинжилгээг хийж гүйцэтгэхэд хамгийн өндөр агууламж 6мкг/м3, улирлын дундаж агууламж 4мкг/м3 хэмжээтэй буюу хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй үнэлгээтэй байна. PM2.5 тоосонцрын 92 удаагийн хэмжилтийг хийхэд хамгийн өндөр агууламж 65мкг/м3, улирлын дундаж агууламж 28мкг/м3 буюу хүлцэх агууламж /MNS4585:2016/-аас давсан тохиолдол бүртгэгдээгүй байна. Төв цэвэрлэх байгууламжийн оролт, гаралтын цэгээс дээж авч шинжилгээг хийж гүйцэтгэхэд цэвэршилтийн зэрэг 70-80%-тай байна. Баруун-Урт, Эрдэнэцагаан суманд орчны цацрагийн агууламжийг тодорхойлох 92 өдрийн 736 хэмжилтийг хийж ажиглахад 0.09-0.12 микроЗверт/цаг хэмжээтэй буюу хүний биед хор нөлөөгүй үнэлгээтэй гарсан байна.

Ганга нуур, Дуут нуурын усны 3 удаагийн 6 дээжид химийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн бол Цацрагийн Ветта идэвхжилт уналтад сорьцыг 9 удаагийн сорьц авч

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид хүргүүлэн хөтөлбөрийн биелэлтийг ханган ажиллаад байна.

Баруун-Урт сумын хөрсний бохирдлыг хянах цэгийг шинэчлэх ажлын хүрээнд нийт 35 цэгийг тодорхойлон дээж авч хөрсний агрохимийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн бол нянгийн болон хүнд металлын шинжилгээнд хамруулахаар Улаанбаатар хотын БОХЗТЛ-д хүргүүлээд байна. Байгаль орчны шинжилгээний ажил үйлчилгээнд 2 удаа калибровка шинэчлээгүй алдаа гарсныг дотоод хяналт шалгалтаар илрүүлэн ажилласан байна.

1.2 Орон нутгийн засаг захиргааны шийдвэрээр хэрэгжүүлсэн ажил үйлчилгээ:

Аймгийн засаг даргын А/447 дугаар захирамжийн дагуу 2024-2025 оны өвөл хаврын бэлчээрийн даац багтаамжийн ажлыг аймгийн хэмжээнд 13 сумын 62 зогсоол цэгийн нийт 3363км замд 8 дугаар сарын 10-наас 20-ны хооронд шугам цэгийн бичиглэл, олон наст ургамлын суурь хоорондын зай, ургамлын төрөл зүйл, ургамлын өндөр, ургамлын ургац, бэлчээрийн доройтлын үнэлгээ, хөрсний гадаргын байдлын үнэлгээ зэрэг анхан шатны ажиглалтыг хийж гүйцэтгэлээ. Баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн код мэдээ боловсруулан Улаанбаатар хот ЦУОШСМХүрээлэнд 8 дугаар сарын 25-нд хүргүүлж ажилласан. 2024-2025 оны өвөл- хаврын бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл: Аймгийн нийт нутгийн 67.0 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой тодорхой тооны мал гаднаас отроор оруулах бэлчээрийн нөөцтэй, 13.0 хувьд гаднаас отрын мал оруулах бололцоогүй тухайн багийн мал өөрийн нутагт өвөлжиж, хаваржихад бэлчээр хүрэлцээтэй, 15.3 хувьд даац 1-3 дахин хэтэрсэн, 4.7 хувьд олон дахин хэтэрсэн. Өөрөөр хэлбэл нийт нутгийн 80 хувьд өвөл, хаврын бэлчээрийн даац хүрэлцээтэй байхаар, харин 20 хувьд бэлчээрийн даац багтаамж хэтэрч гарсан ба өнгөрсөн онтой харьцуулж үзвэл нөөцтэй буюу хүрэлцээтэй бэлчээр 36.9 хувиар өсөж, харин даац хэтэрсэн бэлчээр 36.9 хувиар буурсан байна.

Энэхүү судалгаанаас гарсан үр дүнгийн тайлан мэдээг аймаг орон нутгийн удирдлага, Онцгой байдлын газар, ХХААГазар болон 13 сумын ЗДТГазарт албан бичиг дагалдуулан хүргүүлэн ажилласан. Мөн Sukhbaatar.tsag-gaar.gov.mn, "Sukhbaatar Aimag TsagUur" болон орон нутгийн BBS телевизэд мэдээлэл өгч ард иргэдэд үйлчлэн ажилласан. ЗД-ын А/447 дугаар захирамжийн дагуу 2'218'306 төгрөгийг шийдүүлж бензин шатахуунд зарцуулсан. Бэлчээрийн даац тодорхойлсон үр дүнгээр өвөлжилт хаваржилтын нөхцөл байдал, хадлан тэжээл бэлтгэх, малчдын отор нүүдэл хийх суурь мэдээ бүрдүүлэх нөхцөлийг хангаж ажилласан.

Сүхбаатар аймгийн ОБГ-н гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагын дагуу тус төв нь 11 заалт бүхий шуурхай ажлын төлөвлөгөөг батлуулж байгууллагын галын бүлгэм, гамшгийн штабтай хамтран ажиллаж төлөвлөгөө батлуулан ажилллаж байна. 2024 оны галын аюулгүй байдлын төлөвлөгөөний тодотголыг хийж нийт ажилчдад танилцуулж зааварчилгаа өгсөн.

УЦУОШТ нь орчны эрүүл мэнд, хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нутгийн удирдлагаас өгөгдсөн үүрэг чиглэлийн хүрээнд намрын их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулсан. Үүнд: Байгууллагын нийт ажилчдыг цэвэрлэгээнд бүрэн хамруулж 2 өдрийн турш байгууллагын хуваарьт болон өөрсдийн гадна, ойр орчмын цэвэрлэгээг хийж 3 машин портёр хогыг төвлөрсөн хогийн цэгт аваачиж буулгалаа.



Дүгнэлт:

Байгууллагын үндсэн зорилт болох бүх төрлийн шинжилгээний ажлын чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх зорилтын хүрээнд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасны хэмжээг 13%-иар илүү нэмэгдүүлж ажилласан. Мөн мэдээлэл үйлчилгээний ажил ахисан түвшинд явж байна. Мөн Монгол улсад Цаг уурын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан олон төрлийн арга хэмжээ зохион байгуулан ахмад үе, одоогийн ажиллаж байгаа ажилчдын талархлыг хүлээсэн олон арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.